АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/101-НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Гэрээгээр аудит гүйцэтгэсэн<br>Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар<br>Ахлах аудитор Ч.Анхбаяр<br>Утас: 8511-6555<br>Цахим хаяг: ankha964@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
........ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 10
5.1 Албан шаардлага ........ 10
5.2 Зөвлөмж ........ 11
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БГАҮТХ | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| БШУГ | Боловсрол шинжлэх ухааны газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 68
танай ______ -ны № ______ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.МӨНХЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургууль нь 11,948.5 мянган төгрөгийн бараа материал, 31,645.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "Ерөнхий боловсрол" хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,651,542.2 мянган төгрөг, урсгал санхүүжилт орон нутгаас 373,070.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 151,261.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 11,714.0 мянган төгрөг, нийт 3,191,136.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, төсвийн

зардлын нийт гүйцэтгэлээр 2,894,748.8 мянган төгрөг буюу 90,7 хувьтай зарцуулж, төрийн сангийн дансанд 295,547.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 94 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 90.0 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **280,165,532.62** | **436,766,558.12** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 151,262,186.18 | 295,547,641.68 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 151,262,186.18 | 295,547,641.68 |
| **3121** | **Төгрөг** | 151,262,186.18 | 295,547,641.68 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 151,262,186.18 | 295,547,641.68 |
| **33** | **АВЛАГА** | | 340,550.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 340,550.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 128,903,346.44 | 140,878,366.44 |
| **351** | **Түүхий эд материал** | 108,385,686.44 | 112,015,266.44 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 105,672,277.35 | 109,378,857.35 |
| 35130 | Эм боох материал | 2,713,409.09 | 2,636,409.09 |
| **354** | **Хангамжийн материал** | 20,517,660.00 | 28,863,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,439,660.00 | 28,863,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 78,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,102,023,938.98** | **4,013,206,403.73** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,102,023,938.98 | 4,013,206,403.73 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,923,359,938.90 | 3,834,696,403.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,078,516,587.67 | 4,078,516,587.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -445,445,272.20 | -536,120,365.88 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 36,600,000.00 | 36,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,299,999.88 | -24,399,999.84 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 226,088,846.42 | 247,370,800.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -94,637,619.08 | -122,518,240.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 230,912,258.96 | 283,145,309.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -147,373,309.69 | -168,550,187.74 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 46,117,436.80 | 46,117,436.80 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,608,790.40 | -15,478,387.20 |
| 39217 | Ном | 22,489,800.30 | 10,013,450.30 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 178,664,000.08 | 178,510,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,699,500.00 | 1,699,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,545,499.92 | -1,699,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 178,510,000.00 | 178,510,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,382,189,471.60** | **4,449,972,961.85** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **51,920.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 51,920.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 51,920.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 51,920.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 51,920.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,382,137,551.60** | **4,449,972,961.85** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,382,137,551.60 | 4,449,972,961.85 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 178,510,000.00 | 178,510,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 178,510,000.00 | 178,510,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,906,605,859.95 | 3,974,441,270.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,906,605,859.95 | 3,906,605,859.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 01.00 | 67,835,410.25 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 297,021,691.65 | 297,021,691.65 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,382,189,471.60** | **4,449,972,961.85** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,579,687,496.80** | **3,082,627,881.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **126,745,396.80** | **2,706,009,781.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 126,745,396.80 | 54,467,581.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,197,600.00 | 10,874,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,977,600.00 | 6,049,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,220,000.00 | 4,825,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 111,493,137.00 | 31,645,050.00 |
| 1200018 | Үнэ Төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 7,054,659.80 | 11,948,531.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,966,903,200.00** | **2,651,542,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,966,903,200.00 | 2,651,542,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 3,548,100.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,548,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 486,038,900.00 | 373,070,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 486,038,900.00 | 373,070,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,453,618,544.88** | **2,999,399,750.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,453,618,544.88** | **2,999,399,750.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,276,289,172.80 | 2,873,573,382.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,321,609,596.87 | 1,851,048,555.53 |
| 210101 | Үндсэн цалин | 907,660,239.89 | 1,234,176,980.17 |
| 210102 | Нэмэгдэл | 334,932,674.73 | 480,505,292.07 |
| 210104 | Урамшуулал | 79,016,682.25 | 136,366,283.29 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 166,365,545.15 | 233,511,932.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,936,246.41 | 162,090,331.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,403,896.65 | 18,670,388.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,595,557.22 | 9,310,437.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,581,898.75 | 8,589,596.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,847,946.12 | 34,851,178.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 333,149,539.52 | 348,132,907.49 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,177,402.52 | 23,837,666.00 |
| 210302 | Түлш, халаалт | 275,859,791.00 | 277,014,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,112,346.00 | 47,281,241.49 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36,926,143.00 | 19,398,524.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,227,550.00 | 1,547,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,282,000.00 | 3,350,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,546,543.00 | 14,501,424.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,870,050.00 | 00.00 |
| **2105** | **Норматив зардал** | 114,412,643.00 | 130,525,714.40 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 912,635.00 | 235,280.00 |
| 210502 | Хоол, хүнс | 113,500,008.00 | 130,290,434.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 82,500,000.00 | 9,820,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 82,500,000.00 | 9,820,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,141,490.00 | 13,750,641.63 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,000.00 | 5,871,321.63 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,071,490.00 | 7,879,320.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 211,184,215.26 | 267,385,106.95 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,604,236.20 | 65,944,182.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,119,204.64 | 24,384,510.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 170,460,774.42 | 177,056,414.75 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 177,329,372.08 | 125,826,368.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 106,940,011.60 | 110,889,276.20 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 64,866,911.60 | 71,606,776.20 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 42,073,100.00 | 39,282,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 70,389,360.48 | 14,937,092.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 70,389,360.48 | 14,937,092.51 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **126,068,951.92** | **83,228,130.75** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 15,392,720.50 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 15,392,720.50 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | -15,392,720.50 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **126,068,951.92** | **67,835,410.25** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,461,139,700.00** | **3,039,034,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,197,600.00** | **2,662,416,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,197,600.00 | 10,874,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 8,197,600.00 | 10,874,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,977,600.00 | 6,049,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,220,000.00 | 4,825,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,452,942,100.00** | **376,618,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,966,903,200.00 | 2,651,542,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 3,548,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 486,038,900.00 | 373,070,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 486,038,900.00 | 373,070,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,278,363,017.82** | **2,822,762,294.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,278,363,017.82** | **2,822,762,294.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,102,276,190.66** | **2,695,552,475.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,321,609,596.87 | 1,851,389,105.53 |
| 210101 | Үндсэн цалин | 907,660,239.89 | 1,171,303,828.93 |
| 210102 | Нэмэгдэл | 334,932,674.73 | 543,759,323.40 |
| 210104 | Урамшуулал | 79,016,682.25 | 136,325,953.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 166,365,545.15 | 233,511,932.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,936,246.41 | 162,090,331.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,403,896.65 | 18,670,388.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,595,557.22 | 9,310,437.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,581,898.75 | 8,589,596.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,847,946.12 | 34,851,178.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 333,149,539.52 | 348,132,907.49 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,177,402.52 | 23,837,666.00 |
| 210302 | Түлш, халаалт | 275,859,791.00 | 277,014,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,112,346.00 | 47,281,241.49 |
| **2105** | **Норматив зардал** | 114,464,812.62 | 129,331,530.00 |
| 210502 | Хоол, хүнс | 114,464,812.62 | 129,331,530.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 82,500,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 82,500,000.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,054,200.00 | 34,262,250.63 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,266,200.00 | 6,049,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,788,000.00 | 28,213,250.63 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 69,132,496.50 | 88,924,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,450,496.50 | 71,652,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,682,000.00 | 17,272,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **176,086,827.16** | **127,209,818.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 105,697,466.68 | 112,272,726.20 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 63,624,366.68 | 72,990,226.20 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 42,073,100.00 | 39,282,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 70,389,360.48 | 14,937,092.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 70,389,360.48 | 14,937,092.51 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **182,776,682.18** | **216,272,005.50** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,605,500.00** | **71,986,550.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,605,500.00** | **71,986,550.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,605,500.00 | 71,986,550.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,605,500.00 | 71,986,550.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-49,605,500.00** | **-71,986,550.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 133,171,182.18 | 144,285,455.50 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 18,091,004.00 | 151,262,186.18 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 151,262,186.18 | 295,547,641.68 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 178,510,000.00 | 297,021,691.65 | 3,780,536,908.03 | 4,256,068,599.68 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **178,510,000.00** | **297,021,691.65** | **3,780,536,908.03** | 4,256,068,599.68 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 126,068,951.92 | 126,068,951.92 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **178,510,000.00** | **297,021,691.65** | **3,906,605,859.95** | 4,382,137,551.60 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **178,510,000.00** | **297,021,691.65** | **3,906,605,859.95** | 4,382,137,551.60 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 67,835,410.25 | 67,835,410.25 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **178,510,000.00** | **297,021,691.65** | **3,974,441,270.20** | 4,449,972,961.85 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Харьцуулалт |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,818,066,200.00 | 2,521,678,844.50 | 296,387,355.50 | 89.48 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,818,066,200.00 | 2,521,678,844.50 | 296,387,355.50 | 89.48 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,701,097,200.00 | 2,409,406,118.30 | 291,691,081.70 | 89.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,102,143,500.00 | 1,851,389,105.53 | 250,754,394.47 | 88.07 |
| 210101 | Үндсэн цалин | 1,390,905,700.00 | 1,171,303,828.93 | 219,601,871.07 | 84.21 |
| 210102 | Нэмэгдэл | 628,146,800.00 | 543,759,323.40 | 84,387,476.60 | 86.57 |
| 210104 | Урамшуулал | 83,091,000.00 | 136,325,953.20 | -53,234,953.20 | 164.07 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 262,767,900.00 | 233,511,932.14 | 29,255,967.86 | 88.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 178,682,100.00 | 162,090,331.35 | 16,591,768.65 | 90.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,021,400.00 | 18,670,388.56 | 2,351,011.44 | 88.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,510,700.00 | 9,310,437.69 | 1,200,262.31 | 88.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,510,700.00 | 8,589,596.12 | 1,921,103.88 | 81.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,043,000.00 | 34,851,178.42 | 7,191,821.58 | 82.89 |
| **2105** | **Норматив зардал** | 137,255,600.00 | 129,331,530.00 | 7,924,070.00 | 94.23 |
| 210502 | Хоол, хүнс | 137,255,600.00 | 129,331,530.00 | 7,924,070.00 | 94.23 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 50,198,800.00 | 48,876,250.63 | 1,322,549.37 | 97.37 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,049,000.00 | 6,049,000.00 | 00.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 44,149,800.00 | 42,827,250.63 | 1,322,549.37 | 97.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 148731400.00 | 146297300.00 | 2,434,100.00 | 98.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,600,900.00 | 128,166,800.00 | 2,434,100.00 | 98.14 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,130,500.00 | 18,130,500.00 | 00.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2935035200.00 | 2778237026.20 | 156,798,173.80 | 94.66 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 116,969,000.00 | 112,272,726.20 | 4,696,273.80 | 95.99 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 77,686,500.00 | 72,990,226.20 | 4,696,273.80 | 93.95 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 39,282,500.00 | 39,282,500.00 | 00.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,191,136,200.00 | 2,665,964,300.00 | 152,101,900.00 | 94.60 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,651,542,200.00 | 2,651,542,200.00 | 00.00 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,651,542,200.00 | 2,651,542,200.00 | 00.00 | 100.00 |
| 131002 | Орон нутгийн санхүүжилт | 373,070,000.00 | 373,070,000.00 | 00,00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 162,975,900.00 | 10,874,000.00 | 10,874,000.00 | 06.67 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,049,000.00 | 6,049,000.00 | 6,049,000.00 | 100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,665,000.00 | 4,825,000.00 | 4,825,000.00 | 85.17 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 151,261,900.00 | 00.00 | 151,261,900.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 151,262,186.18 | 151,262,186.18 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 295,547,641.68 | 295,547,641.68 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 81 | 80 | 80 | 80 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 52 | 51 | 51 | 51 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 28 | 28 | 28 | 28 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 746.00 | 756.00 | - | 96.4 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 746.00 | 756.00 | - | 96.4 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 746.00 | 756.00 | - | 96.4 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,015.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

- Тайлант онд өмч хамгааллын шийдвэрээр 16 ш 4,015.0 мянган төгрөгийн аж ахуйн материалаас акталсныг тайлант жилийн 210406 бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаар журналын бичилт хийснийг, 210408 бараа материал акталсны гарз дансаар залруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **41,923.2** мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, зөрчил таслан зогсоож, арилгуулах 1 албан шаардлага 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг бус алдаа зөрчил нь 41,582.6 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **22,337.98** мянган төгрөг, шинж чанарын хувьд материаллаг бус байгаа тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант жилд 340.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд 41,582.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасугай" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж***: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардлын дансны аннилал залруулсан | 1 | 4,015.0 | | | 1 | 4,015.0 | 1 | 4,015.0 | | | | |
| **Дүн** | 1 | 4,015.0 | | | 1 | 4,015.0 | 1 | 4,015.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах | Хууль, хяналтын байгууллагад |

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | албан шаардлага | | шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Т о о | Албан тушаал тны тоо | Тоо | Дүн |
| Шууд гэрээгээр худалдан авалт хийсэн | 1 | 41,582.6 | | | | | 1 | 41,582.6 | | | | |
| Авлага | 1 | 340.5 | | | | 340.5 | | | | | | |
| Дүн | 1 | 41,582.6 | | | 1 | 340.5 | 1 | 41,582.6 | | | | |